

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 100 ЖИЛИЙН ОЙ,
МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ГИШҮҮНЭЭР
ЭЛССЭНИЙ 50 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ХӨДӨЛМӨР МИНИЙ ДУРАНД”
ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

ЗОРИЛГО:

Ажил, мэргэжил, хөдөлмөрийн өнөөгийн өнгө төрх, онцлог, шинж чанар, хөдөлмөрийн амт, үр шим, өнөөдрийн хөдөлмөрийн зах зээлд тулгамдаж буй асуудлууд болон ирээдүйд бий болох ажил, мэргэжлийн төсөөллийг гэрэл зургийн агшинд буулгах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг сурталчлахад энэхүү уралдааны зорилго оршино.

ОРОЛЦОГЧДОД ТАВИХ ШААРДЛАГА:

- Нас, хүйс, мэргэжил, шашин шүтлэг, үндэстэн, ястан харгалзахгүй хэн бүхэн оролцох боломжтой.
- 18 нас хүрээгүй хүүхэд оролцож буй тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч нь зохиогчийн эрхийн асуудлыг хариуцах болно.

ХУГАЦАА:

- 2018 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэл;

БҮТЭЭЛ ИРҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС:

- Оролцогч бүр 3-5 зураг ирүүлнэ /Файлаар болон хэвлэсэн байдлаар/.
- Зургийг А4 хэмжээтэй хэвлэсэн байх;
- Бүтээлдээ нэр өгсөн байх ба зургийн тайлбарыг товч, тодорхой, ойлгомжтойгоор өгсөн байхыг анхаарна.
- Оролцогч эх бүтээлээ файл хэлбэрээр хүргэхдээ 30 см х 20 см DPI 300 хэмжээтэй бэлтгэж, ilo50years@fcy.gov.mn цахим хаягаар, эсхүл CD, Flash Driver/USB Stick дээр хуулж, өөрийн дэлгэрэнгүй мэдээлэл, холбоо барих хаягийн хамт биечлэн хүргэж болно.
- Хэвлэсэн байдлаар ирүүлэхдээ шуудан эсхүл зохион байгуулагчдын хаягаар хүргэж болно.
- Таны зураг RAW файл бол JPG формат руу хөрвүүлсэн байх шаардлагатай. Эх зургийн талаарх танилцуулга буюу хэзээ, ямар камераар авсан тухай мэдээлэл компьютер дээр шалгахад байх ёстойг анхаарна уу.
- Зохиогчийн нэр, бүтээлийн нэр, утсыг бүтээлийн ард заавал бичсэн байна.
- Хөдөө орон нутгийн оролцогчид бүтээлээ шаардлагын дагуу бэлтгэн, зохион байгуулагчид руу шуудангаар, ilo50years@fcy.gov.mn цахим хаягаар, эсвэл бусад холбоо, харилцааг ашиглан хүргэж болно.

ГЭРЭЛ ЗУРГИЙН НӨХЦӨЛ БА ШАЛГУУР:

- Бүтээлийн зохиомж, агуулга, ур чадвар, бүтээлийн нэр, тайлбар, тухайн бүтээл чанарын шаардлага хангасан эсэхийг харгалзан шүүнэ.

- Зөвхөн өөрийн авсан гэрэл зураг байх ёстой бөгөөд зохиогчийн эрхийн асуудал үүссэн тохиолдолд зохион байгуулагч тал хариуцахгүй.
- Гэрэл зураг нь эх хувиар байх ёстой ба засвартай зургийг хүлээн авах боломжгүй;
- Шүүгчид бүтээлийг гурван үзүүлэлтээр шалгаруулна.

Үүнд:

- Бүтээлийн уран сэтгэмж ба зурагчны авъяас чадвар;
- Гэрэл зургийн чанар ба техникийн бусад үзүүлэлт;
- Бүтээлийн агуулга ба нэр, тэдгээрийн шүтэлцээ.

ЗОХИОГЧИЙН ЭРХ:

- Гэрэл зургийн зохиогчийн эрх нь зураг авсан хувь хүнд байна.
- Уралдаанд ирүүлсэн бүтээлийг буцааж олгохгүй бөгөөд зохион байгуулагчдын гэрэл зургийн сан хөмрөгт үлдэнэ.
- Зургийг бусад хувь хүн, байгууллагад худалдах, шилжүүлэх, хэлбэрээр ашиглуулахгүй байх үүргийг зохион байгуулагч тал бүрэн хариуцах болно.
- Шагналт байранд шалгарсан, эхний 3 байранд орсон гэрэл зургийн зохиогчийн эрх нь зохиогчдод үлдэх ба цаашид ном, сэтгүүлд хэвлэх, сурталчилгаа, хамгааллын ажилд ашиглах эрх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, түүний харъяа байгууллагад үлдэхийг зохиогч зөвшөөрнө. Ашиглах тохиолдолд зурагчны нэрийг заавал дурьдана.
- Шагналт байранд ороогүй ч, уралдаанд ирүүлсэн бүтээлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага зэрэг санаачлагч, зохион байгуулагч байгууллага хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны чиглэлээрх сурталчилгааны зорилгоор ашиглах тохиолдолд зохиогчоос зөвшөөрөл авахгүй. Ашиглах тохиолдолд гэрэл зурагчны нэрийг үргэлж дурьдана.
- Уралдааныг сурталчлах, ажил, хөдөлмөртэй холбоотой ажлыг нийтэд хүргэх зорилгоор гэрэл зургуудыг сонин хэвлэл, вэбсайт, цахимхуудсанд нийтлэх, гэрэл зургийн үзэсгэлэн гаргахыг уралдаанд оролцогчид зөвшөөрнө.
- Гэрэл зургийн зохиогчийн эрхтэй холбоотой үүссэн маргаантай асуудлыг санаачлагч, зохион байгуулагч болон гэрэл зурагчин харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ШҮҮГЧ БА ГЭРЭЛ ЗУРАГ ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ:

- Гэрэл зургийг хөдөлмөр эрхлэлтийн туршлагатай мэргэжилтэн, мэргэжлийн гэрэл зурагчид, зохион байгуулагчаас бүрдсэн баг шалгаруулна.
- Шүүгчид шалгуур үзүүлэлтийн дагуу 1, 2, 3 дугаар байр шалгаруулна. Гэрэл зургийг шүүгчдийн бүрэлдэхүүний санал болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан ёсны **facebook** хуудсаар санал авч, шалгаруулна.
- Уралдаанд шалгарсан бүтээлээр гэрэл зургийн үзэсгэлэнг гаргана.
- Уралдааны эхний 3 байр эзэлсэн оролцогчдыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээр зарлаж танилцуулах ба үр дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын сайтад байршуулна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

Ерөнхий зохион байгуулагч:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага;
- Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо;
- Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо.

Хамтран зохион байгуулагч:

- Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газар;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт.

1. ШАГНАЛЫН САН:

- 1 дүгээр байр: өргөмжлөл, мөнгөн шагнал – 1 000 000 төгрөг;
- 2 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 700 000 төгрөг;
- 3 дугаар байр: өргөмжлөл, мөнгөн шагнал - 400 000 төгрөг.

Жич: Уралдаанд шалгарсан бүтээлүүдийн шагналыг 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр болох **“Ирээдүй ажил, мэргэжил”** зөвлөгөөний үеэр гардуулж, үзэсгэлэнд тавьж танилцуулна.

Бүтээлийг хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Төрийн өмчийн 11 дүгээр байр, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 213 тоот

- **Холбогдох утасны дугаар:** 62263093, 80027744, 86882222
- **Цахим хаяг:** ilo50years@fcy.gov.mn

---oO---